



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/944

Мандалговь

Хот тохижуулах газрын албан
хэрэгцээнд универсал трактор
хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журамын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд универсал трактор хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Ж.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Отгонсайхан (Мандалын гэгээ хот тохижуулах газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Ерөнхий инженер)

Ж.Базарсад (Мандалын гэгээ хот тохижуулах газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хог хариуцсан инженер)

Б.Дорждэрэм (Монтех дистрибьюшн ХХК-ийн менежер)

Нарийн бичгийн дарга:

Г.Ундармаа (Мандалын гэгээ хот тохижуулах газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нярав)

2. Тракторыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Ж.Уянга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100643